# БАЯНХОНГОР АЙМАГ
# БААЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 11 өдөр Дугаар А/10 Баянсайр

Баг, хот айлд төрийн үйлчилгээ
хүргэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1. 77 дугаар зүйлийн 77.1, сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Хөдөөгийн иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулж, хууль тогтоомж, төрийн бодлого шийдвэр, аймаг сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг танилцуулах, мэдээлэх, цаг үеийн ажлын мэдээлэл хүргэх, өвөлжилтийн байдалтай танилцах, өвөлжилтийн хүнд үед малчдад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, тэдний санал хүсэлтийг сонсож, цаашид гаргах шийдвэрт тусгах, төр иргэний эргэх холбоог бэхжүүлэх зорилгоор 2022 оны 01 дүгээр сард төрийн байгууллагууд хуваарьт багт ажиллах ажлын хэсэг томилж, гүйцэтгэх ажлын удирдамж, хөтөлбөрөө батлуулж ажиллахыг байгууллагын дарга, захирал, эрхлэгч багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Төрийн байгууллагуудын багт ажиллах хуваарийг хавсралтаар батлсугай.

3 . Хөдөө багт төрийн үйлчилгээг хүргэж ажилласан тухай тайланг 2022 оны 02 дугаар сарын 25-ны дотор Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Бямбаням/-д даалгасугай.

ДАРГА С.ЭНХТӨР

642101276

Засаг даргын 2022 оны 01 дугаар
сарын 11-ны өдрийн А/10 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН БАГТ
АЖИЛЛАХ ХУВААРЬ

| д/д | Багийн нэр, дугаар | Харъяа багийн Засаг дарга, багийн эмч | Багт ажиллах төрийн байгууллага, хариуцах албан тушаалтан | Хугацаа |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Баянбыулаг 1 дүгээр баг | П.Баттэрэл<br>Б.Байгальмаа | Соёлын төв<br>Х.Соёл-Эрдэнэ | 01 дүгээр сарын 17-21 |
| 2 | Оройнбууц 2 дугаар баг | Т.Билэггэндэн<br>Н.Цэцгээ | "Цагаан далай" дунд сургууль<br>Г.Насанбаяр | 01 дүгээр сарын 17-21 |
| 3 | Буйлсан 3 дугаар баг | Ж.Солонго<br>Д.Сугарсүрэн | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал<br>Ц.Энхтуяа | 01 дүгээр сарын 17-21 |
| 4 | Могой 4 дүгээр баг | П.Мөнхжаргал<br>П.Сугарсүрэн | Засаг даргын тамгын газар<br>Б.Наранбаатар | 01 дүгээр сарын 17-21 |
| 5 | Товгор 5 дугаар баг | Д.Баттөр<br>Д.Хоролдулам | Эрүүл мэндийн төв<br>Д.Болормаа | 01 дүгээр сарын 17-21 |
| 6 | Зүүнхаяа 6 дугаар баг | Г.Баянжаргал<br>П.Дулам | Хүүхдийн "Жаргалан" цэцэрлэг | 01 дүгээр сарын 17-21 |

__________oOo__________